

**ЗАВХАН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

**“ОЧИР-ИЛЧ” ОРОН НУТГИЙН ӨМЧИТ АЖ АХУЙН ТООЦООТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН
2017 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН**



**Тус байгууллагын үйл ажиллагаа нь эдийн засгийн тооцоо судалгаа,
төлөвлөлтгүй, урсгалаар явж байна.**

Улиастай хот 2018 он

Аудитыг гүйцэтгэсэн:

Ахлах

аудитор Д.Оюунжаргал

Утас: 99460422

Аудитор Б.Жалбаа

Утас: 89330330

Хянасан :

Дарга, тэргүүлэх

аудитор Л.Уламбаяр

Аудитын менежер

Г.Хашцэцэг

Хаяг: Завхан аймаг

Нутгийн удирдлагын

ордон 309, 310 тоот

өрөө

Агуулга

1. Аудитын зорилт, хамрах хүрээ, арга зүй.....4-5
2. Бүлэг 1 Тайлант онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн биелүүлсэн эсэх.....5-5
3. Бүлэг 2 Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулаагүй байна.....5-10
4. Бүлэг 3 Хөрөнгийн худалдан авалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт үр дүнтэй эсэх.....10-11
5. Дүгнэлт. Тус байгууллагын үйл ажиллагаа нь эдийн засгийн тооцоо судалгаа, төлөвлөлтгүй, урсгалаар явж байна.....11
6. Зөвлөмж.....12

Товчилсон үгийн тайлбар

- **УИХ**-Улсын Их хурал
- **ИТХ**-Иргэдийн Төлөөлөгсдийн Хурал
- **ТУЗ**-Төлөөлөн удирдах зөвлөл
- **ОНӨААТҮГ**-Орон нутгийн өмчид аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
- **ААНОАТ**-Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
- **НӨАТ**-Нэмэгдсэн өртөгийн албан татвар
- **ХХОАТ**-хүн амын орлогын албан татвар
- **ҮХХАТ**-Үл хөдлөх хөрөнгийн албан татвар

Аудитын зорилт, хамарсан хүрээ арга зүй:

1. Аудит хийх үндэслэл, бүрэн эрх

Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2018 оны А/06 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний аудитын газрын 2018 онд гүйцэтгэх аудитын сэдвийн төлөвлөгөө”-г үндэслэн Аймгийн ИТХ-ын захиалгаар Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд аудитыг хийж гүйцэтгэлээ.

2. Аудитын зорилт

“Очир-Илч” орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2017 оны үйл ажиллагааны үр дүн”-д аудит хийж, дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцууллаа. .

Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудит хийлээ. Үүнд:

- Тайланд онд дэвшүүлсэн зорилго, зорилтын биелэлт
- Байгууллагын үйл ажиллагааны орлого бүрдүүлэлт, зарцуулалт
- Хөрөнгийн худалдан авалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт үр дүн

3. Аудитын хамрах хүрээ

Завхан аймгийн “Очир-Илч” орон нутгийн өмчийн аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын 2017 оны үйл ажиллагааг хамрууллаа.

4. Ерөнхий мэдээлэл

Тус газар нь 2011 онд байгуулагдсан бөгөөд 300 орчим ажлын байр бий болгон өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүнийг худалдаалах үйл ажиллагаа эрхэлдэг бөгөөд түрээсийн орлогоор өөрийгөө санхүүжүүлэн ажиллаж байна.

Тус байгууллага нь гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, дотоод хяналт бичиг хэргийн ажилтан, орлогын байцаагч, харуул, үйлчлэгч гэсэн нь нийт 12 орон тоотой үйл ажиллагаагаа явуулж байна.

5. Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэхэд Гүйцэтгэлийн аудитын удирдамж АДБОУС 3000-3100, гүйцэтгэлийн аудитын журмыг ашигласан бөгөөд шалгагдагч байгууллагын холбогдох албан тушаалтан нартай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, санхүүгийн болон ажлын тайланг судлах, нөхцөл байдлын шинжилгээ хийж аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулан ажиллаа.

6. Аудитын хугацаа,

Аудитыг 2018 оны 05 сарын 01-нээс 2018 оны 05 сарын 31-ны дотор гүйцэтгэж, тайланг холбогдох албан тушаалтангуудад хүргүүлэн ажиллаа.

Аудитын тайланд дэвшүүлсэн зорилт, хамарсан хүрээ, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмжөөс гадна шалгагдагч байгууллагын саналыг тусгасан болно.

7. Аудит хийх багийн бүрэлдэхүүн

Аудитыг дарга бөгөөд тэргүүлэх аудитор Л.Уламбаяр хянан удирдаж, аудитын менежер Г.Хашцэцэг аудитын үе шатны чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Оюунжаргал, Аудитор Б.Жалбаа нар аудитыг гүйцэтгэв.

БҮЛЭГ 1.Тайлант онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо бүрэн биелүүлсэн эсэх

2017 онд тодорхой зорилго, зорилт дэвшүүлээгүй, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж батлуулан ажиллаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 /үйлдвэрийн газрын үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, зохих байгууллагаар батлуулан биелэлтийг хангах/ гэсэн заалтыг зөрчиж байна.

Аймгийн ИТХ-ын 2016 оны 8 дугаар сарын 31-ний 52 тоот тушаалаар “Очир-илч” ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийг 5 хүний бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулан ажиллаж ирсэн ч ТУЗ-ын хурлаар зорилго, зорилт, үйлдвэрлэл, санхүүгийн төлөвлөгөөг хэлэлцэн батлаагүй, биелэлтийг тооцон ажиллаагүй байна.

Аудитаас дээрх асуудлуудын талаар зөвлөмж өгч ажиллаа.

БҮЛЭГ 2. Үйл ажиллагааны орлого, зарлагын төлөвлөгөөг ТУЗ-өөр хэлэлцүүлэн батлуулаагүй байна.

2.1 Үйл ажиллагаанаас орох орлогыг огт төлөвлөөгүй байна.

“Очир-Илч” ОНӨААТҮГ-ын 2017 онд ТУЗ-өөр батлуулсан орлогын төлөвлөгөө, тооцоолол хийсэн судалгаа байхгүй байна.

Харин 2018 онд орлогыг төлөвлөж, ТУЗ-ийн дарга, гишүүдээр батлан ажилласан байна.

Аудитын явцад тус байгууллагын 2017 онд орох орлогыг тооцоолж үзэхэд 162 түрээслэгчээс 186,3 сая төгрөгийн талбайн орлого, хөрөнгийн /хөлдөөгч, хөргүүр/ түрээсээр 1,0 сая төгрөгийн нийт 187,3 сая төгрөгийн орлого орох тооцоог гаргалаа.

Энэ нь нийт хүчин чадлын 54 хувь байна.



2017 онд “Очир-Илч” ОНӨААТҮГ нь түрээсийн орлогоор 178,9 сая төгрөг, бусад орлогоор 0,2 сая төгрөгийн орлого төвлөрүүлэн ажилласан байна.

Орлогыг задлан харахад өмнөх оны төлөгдөөгүй үлдэгдлээс 10,5 сая төгрөг, тайлант онд орох орлогоос 168,4 сая төгрөг төвлөрсөн байна.

Дээрх тооцооллоос харахад тайлант онд орох орлого 18,9 сая төгрөөр тасарч, түрээсийн авлага 68,1 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

2017 оны нийт орлогыг 2016 онтой харьцуулахад 39,2 сая төгрөг буюу 18 хувиар буурсан үзүүлэлттэй байна.

Орлого буурахад нөлөөлсөн гол хүчин зүйл нь эдийн засгийн тогтвортой бус байдал нөлөөлсөн байна гэж үзлээ.

Аудитын явцад түрээсийн орлогыг түрээслэгч тус бүрийн гэрээтэй тулган баталгаажуулалт хийхэд гэрээний хугацааг он дамнуулан байгуулсан, сунгалт хийгдээгүй, зарим түрээслэгчидтэй байгуулсан гэрээ байхгүй зэрэг зөрчил илэрсэн.



Энэ нь түрээсийн орлогыг бодитой тооцоолж, бүрэн төвлөрүүлсэн эсэхэд дүгнэлт өгөхөд нөлөөлж байна.

Иймд цаашид гэрээний хугацааг тухайн онд багтаан байгуулж, сунгалтыг тухай бүр хийж, түрээслэгч нартай тооцоо бодон гарын үсгээр баталгаажуулан ажиллаж байх шаардлагатай байна гэж үзлээ.

Аудитаар тус байгууллага бүрэн хүчин чадлаараа ажилласан нөхцөлд орлого нэмэгдэх боломж байна гэж үзлээ.

Одоогийн түрээсийн орлогоор сард 15,5 сая төгрөг төвлөрүүлж байна. Харин бүрэн хүчин чадлаараа ажилласан нөхцөлд түрээсийн орлогоор сард 19,7 сая төгрөг буюу орлого нэмэгдэх боломж сард 4,2 сая төгрөг байна. Жилийн дүнгээр тооцоход 50,4 сая төгрөг болж байна гэж үзлээ.

2017 оны үйл ажиллагааны орлогыг тайлагнасан байдлыг татварын тайлангаас судлан үзэхэд ААНОАТ-ын тайланд 16,2 сая төгрөгийн, НӨАТ-ын тайланд 13,2 сая төгрөгийн орлогыг тус тус дутуу тайлагнасан байна.

Энэ нь тухайн байгууллагын тайлант оны алдагдлыг нэмэгдүүлсэн байна.

2.2. Зардал хямдруулах саналыг орон нутгийн удирдлагууд дэмжин ажлаагүй байна.

2017 онд ТУЗ-ийн хурлаар төсвийг хэлэлцүүлэн батлуулаагүй, нийт 179,2 сая төгрөгийн зардал гарган ажилласан байна.

Үүнийг задлан харвал дараах байдалтай байна.

д/д	Зардлын төрөл	ДҮН	хувь
1	Цалин хөлс, түүнтэй адилтгах орлого	74,97	41,8
3	НДШ	8,3	4,6
4	Түлш халаалт	39,76	22,2
5	Гэрэл цахилгаан	17,0	9,5
6	Цэвэр бохир ус	5,76	3,2
7	Шуудан холбоо	1,2	0,7
8	Тээвэр шатахуун	1,1	0,6
9	Бичиг хэрэг	0,45	0,3
10	Томилолт	0,2	0,1
11	Аж ахуйн материал	5,2	3,0
12	Сэлбэг	0,65	0,4
14	Хог хаягдал	1,5	0,8
16	Нэг удаагийн тэтгэмж	1,7	0,9
17	Татвар	13,5	7,5
18	Урсгал засвар	0,29	0,2
19	Акт төлбөр	2,9	1,6
20	Ажлаас халагдсаны тэтгэмж	3,5	2,0
21	Бусад	0,5	0,3
22	Хөрөнгийн зардал	0,5	0,3
ДҮН		179,2	100

Зардлын 78,1 хувийг цалин хөлс болон түүнтэй адилтгах зардал, түлш халаалт, гэрэл цахилгаан гэсэн 3 зардал эзлэж байна.

Түлш халаалтын зардал өндөр байгаагаас жил бүр өр үүсэж, үүний улмаас дулаан эрчим хүчээр хангах гэрээ зөрчигдөж, төлөгдөөгүй үлдэгдэлд хоног дутамд нь 0,3 хувийн алданги ногдуулж байгаа нь санхүүд хүндрэл учруулж байна.

Түлш халаалтын зардлыг бууруулах талаар дараах арга хэмжээг авч ажилласан боловч үр дүнд хүрээгүй байна.

- ❖ Аймгийн засаг даргын мөрийн хөтөлбөр болон 2017, 2018 оны нийгэм эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлд өөрийн халаалтын уурын зуухтай болох, ингэснээр түлш халаалтын зардлыг 40,0 сая төгрөгөөр хэмнэх боломж байгаа талаар тооцоо, судалгаа гарган хүргүүлсэн байна.

Гэтэл орон нутгийн удирдлагууд “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.5/ орон нутгийн өмчит албан байгууллагыг шаардлагатай эд хөрөнгөөр хангах/-д заасан бүрэн эрхээ хэрэгжүүлээгүй байна.

- ❖ Түрээслэгчдээс аймгийн засаг даргад түрээсийн төлбөрийн ихэнх хувийг халаалтын төлбөрт өгдөг нь алдагдалтай ажиллахад хүргэж байна гэсэн саналыг хүргүүлсэн байна.

Уг саналын хүрээнд “Очир-Илч” ОНӨААТҮГ нь “Уулс Дөл” ХХК-д халаалтын үнийг бууруулах талаар хүсэлт хүргүүлсэн ч халаалтын үнийн хамгийн баг тарифаар тооцдог учир хүсэлтийг хүлээн авах боломжгүй гэсэн хариу ирүүлсэн байна.

Судалгаанаас харахад төсвийг арвилан хэмнэлттэй зарцуулах боломж байжээ гэж үзлээ. Тухайлбал:

- Батлагдсан орон тооноос 1-4 хүн илүү ажиллуулж цалингийн зардлыг 9,6 сая төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан
- Шуудан холбооны зардлын 1,2 сая төгрөгийн 0,9 сая төгрөг нь гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, бичиг хэргийн ажилтаны гар утасны төлбөрт төлсөн нь “Очир-Илч” ОНӨААТҮГ-ын хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар бүлгийн 8.13-д байгууллагын үйл ажиллагаанд зориулж холбооны зардлыг сар бүр гүйцэтгэх захиралд 50000 төгрөг, менежер-нягтлан бодогч, дотоод хяналт-бичиг хэргийн ажилтанд тус бүр 15000 төгрөг олгож болно гэсэн заалтыг үндэслэжээ.

Аудитаар дотоод журмын уг заалтыг тухайн байгууллага ашигтай ажилласнаас хойш хэрэгжүүлэх, УИХ-ын 2017 оны 04 сарын 14-ны өдрийн 29 дугаар тогтоолоор гар утасны төлбөрийг төсвөөс санхүүжүүлэхгүй байх чиглэл өгөгдсөн зэргийг харгалзан үзэх нь зүйтэй гэж үзлээ.

- Тээвэр шатахууны зардалд 1,1 сая төгрөгийг зарцуулсан бөгөөд жолоочын тооцоог тухай бүр бодоогүй байна.
- Ажлын хариуцлагагүй байдлаас үүдэн гарсан актын төлбөр 2,9 сая төгрөгийг байгууллагын төсвөөс төлсөн, Үүний 1,5 сая төгрөгийг эзэн холбогдогчдоос гаргуулан төлүүлээгүй,
- Ажлаас халагдсаны тэтгэмжинд 3,5 сая төгрөгийг олгосон зэрэг нийт 18,0 сая төгрөгийн үрэлгэн зардал гаргажээ.

Цаашид зардлын төсвийг бодитой төлөвлөн батлуулж, батлагдсан төсвийн хүрээнд зардал гарган, төсвийг үр ашигтай зориулалтын дагуу зарцуулж байх нь зүйтэй байна.

Мөн аудитын явцад бичиг баримтын эмх цэгц хангалтгүй, баримтын бүрдэл дутуу зэрэг зөрчил илэрсэнд анхаарч ажиллах шаардлагатай байна.

Аудитаар Очир-Илч ОНӨААТҮГ-ын авлага, өглөгийг судлан үзэхэд дараах байдалтай байна. Үүнд.

Авлага:

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 68,1 сая төгрөгийн түрээсийн авлага, 0,2 сая төгрөгийн татвар, нийгмийн даатгалын авлага, 7,8 сая төгрөгийн найдваргүй авлага тусгагдсан байна.

Аудитын явцад авлагыг барагдуулах талаар ямар арга хэмжээ авч ажиллаж байгааг судлан үзэхэд 52 түрээслэгчтэй холбоотой 41,2 сая төгрөгийн авлагыг

барагдуулахаар шүүхийн байгууллагад шилжүүлсэн байна. Үүнээс 17 түрээслэгчтэй холбоотой 18,5 сая төгрөгийн авлага нь хуваарийн дагуу төлөгдөж байна. Харин бусад түрээслэгчидтэй холбоотой авлага шүүхийн шатандаа явж байна.

Зарим түрээслэгчид авлагыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа нь гэрээний хугацаанд сунгалт хийх бүрдээ тооцоо нийлж үлдэгдлийг гарын үсгээр баталгаажуулаагүйтэй холбоотой байна.

Найдваргүй авлага үүссэн шалтгаан нөхцөлийг тодруулахад анх үүсгэн байгуулагдаж түрээслэгчдэд лангуу олгохдоо эмх замбараагүй олгосон, дамжуулан түрээслүүлсний улмаас эзэн нь тодорхойгүй үүсэн авлага байна.

Өглөг:

2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд 14,4 сая төгрөгийн татварын өглөг, 189,3 сая төгрөгийн дансны өглөг, нийт 203,7 сая төгрөгийн өглөг тусгагдсанаас 24,3 сая төгрөгийн өглөг нь 2017 онд шинээр нэмэгдсэн байна.

Татварын өглөг: НӨАТ 4,5 сая төгрөг, суутгагчийн хувь хүнд олгосон орлого 0,1 сая төгрөг, ХХОАТ 1,6 сая төгрөг, ҮХХАТ 8,2 сая төгрөг байна.

Дансны өглөг: Түлш халаалт 32,8 сая, цэвэр бохир ус 2,3 сая, орон нутгийн өмчийн төлбөр 154,2 сая төгрөг байна.

Орон нутгийн өмчийн төлбөр нь “Очир-Илч” ОНӨААТҮГ байгуулагдсанаас хойш хуримтлагдсан өглөг бөгөөд уг төлбөр нь тус байгууллагын орлогын 20 хувиар тооцон байгуулсан байна.

“Очир-Илч” ОНӨААТҮГ нь орон нутагт төлөх татварыг орлогын 20 хувиар төлөх боломжгүй, ашгийн 20 хувиар тооцох тухай саналыг ТУЗ-өөр хэлэцүүлэн Аймгийн ИТХ болон засаг даргад хүргүүлснээр орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварыг Аймгийн засаг даргын 2016 оны А/278 тоот захирамжаар ашгийн 20 хувийг орон нутгийн төсөвт төлж байхаар өөрчилсөн байна.

2.3 Батлагдсан орон тоогоор ажиллаагүйн улмаас зардлыг 13,1 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн байна.

“Очир-Илч” ОНӨААТҮГ-ын ТУЗ-ийн 2016 оны 11 сарын 29-ний өдрийн 7 дугаар хурлын шийдвэрээр ажилчдын цалингийн сан, орон тоог 11 хүний бүрэлдэхүүнтэй байхаар батласан байна.

Гэтэл батландсан орон тоо 1-4 хүнээр илүү ажиллаж цалинд 9,6 сая төгрөг, ажлаас халагдсан албан хаагчдад шүүхийн шийдвэр болон шийдвэргүй тэтгэмжинд 3,5 сая төгрөг, нийт 13,1 сая төгрөгийн үрэлгэн зардал гаргаж, тус газрын санхүүгийн үйл ажиллагаанд хүндрэл учруулсан байна.

/Энэ нь төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.3. “батлагдсан цалингийн сан, орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагчдын цалин

хөлсийг тогтоох”, 16.5.4.”төсвийн байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх” 16.5.5. ”батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтуудыг зөрчжээ./

2018 онд бүтэц орон тоог 12 байхаар баталсан байна. Үүнд. Гүйцэтгэх захирал, нягтлан бодогч, дотоод хяналт-бичиг хэрэг, нярав-орлогын байцаагч, харуул, үйлчлэгч гэсэн бүтэцтэй байна.

2.4 Байгууллагын үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

ТУЗ нь 2017 онд нэг удаа хуралдаж “Очир-Илч” ОНӨААТҮГ-ын гүйцэтгэх захирлыг томилох тухай асуудлыг хэлэлцсэн байна. Харин тус газрын үйл ажиллагаа болон тайлан мэдээтэй холбоотой асуудлыг хэлэлцээгүй байна.

Тус байгууллагад дотоод хяналт-бичиг хэрэг хариуцсан орон тоо ажиллаж байгаа бөгөөд дотоод хяналт шалгалтын журам боловсруулан хүнсний болон бараа бүтээгдэхүүний ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангаж буй талаар хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн байна.

2017 онд санхүүгийн хяналт, дотоод аудитын алба, орон нутгийн өмчийн алба зэрэг байгууллагуудаас хяналт шалгалт хийсэн ч 2017 оны үйл ажиллагааг хамруулаагүй байна.

Аймгийн ИТХ болон ТУЗ-өөс тус газрын үйл ажиллагаатай танилцаж, шалгалт хийсэн гэсэн тайлбарыг Очир-Илч ОНӨААТҮГ-ын удирдлагаас өгсөн хэдий ч албажуулсан зөвлөмж, үүрэг даалгавар байхгүй байна.

2.5 Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэн ажиллах талаар үүрэг даалгавар өгөгдсөн байна.

2017 онд “Очир-Илч” ОНӨААТҮГ-ын шилэн дансны мэдээлэлд Санхүүгийн хяналт аудитын алба хагас жилээр шалгалт хийхэд хэрэгжилт 63,8 хувьтай байгаа нь шаардлага хангахгүй тул холбогдох албан тушаалтанд хариуцлагын арга хэмжээ авах тухай тоот хүргүүлэн ажилласан байна.

Мөн Төрийн аудитын газраас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгах нийцлийн аудитын хүрээнд тус газарт албан шаардлага хүргүүлэн ажилласан байна.

Аудитын явцад дээрх үүрэг даалгавруудын биелэлтийг шалган үзэхэд шилэн дансы мэдээллийг цахим мэдээллийн санд өгөгдсөн үүрэг даалгаврын дагуу оруулсан байна.

Аудитаар орлогын бүрдүүлэлт, зарцуулалттай холбоотой 47.7 сая төгрөгийн зөрчил илрүүлж, үүнээс 2.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоолоо.

БҮЛЭГ 3. Хөрөнгийн худалдан авалт, хадгалалт, хамгаалалтанд тавих хяналт үр дүнтэй эсэх

Тус байгууллага тайлант онд шинээр хөрөнгө худалдан аваагүй байна.



Харин аймгийн ИТХ-ын шийдвэрээр 14,0 сая төгрөгийн үнэтэй 00-09 ЗАН дугаартай Ланд-80 автомашиныг “Амь-ус” ОНӨААТҮГ-аас балансаас балансад шилжүүлэн авч данс бүртгэлд тусган, ашиглаж байна.



Аудитын явцад өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалтай газар дээр нь танилцаж үндсэн болон эргэлтийн хөрөнгөнд хэсэгчилсэн тооллого хийхэд шаардлага хангахгүй биет элэгдэлд орж, хуучирч муудсан, эвдэрхий 15 нэр төрлийн нийт 13115,6 мянган төгрөгийн үлдэгдэл үнэтэй хөрөнгүүд байна.

Ашиглах боломжгүй, актлах шаардлагатай хөрөнгүүдийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 /Аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар үндсэн хөрөнгийг зөвхөн төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын зөвшөөрөлтэйгээр данснаас хасах буюу борлуулах, устгах эрхтэй/ гэсэн заалтын дагуу зохих байгууллагад санал оруулж шийдвэрлэх нь зүйтэй гэж үзлээ.

Хөрөнгөнд хэсэгчилсэн тооллого хийхэд дутагдал илрээгүй болно.

Дүгнэлт: Тус байгууллагын үйл ажиллагаа төлөвлөлт, эдийн засгийн тооцоо судалгаагүй урсгалаар явагдаж байна.

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР

ЗӨВЛӨМЖ

Очир-Илч ОНӨААТҮҮГ-ын захирал Т.Алимаа-д

Үндэсний аудитын газрын төлөвлөгөөг үндэслэн аймгийн ИТХ-ын захиалгаар гүйцэтгэсэн “Очир-Илч” ОНӨААТҮГ-ын 2017 оны үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгөх гүйцэтгэлийн аудитаар илэрсэн алдаа зөрчилд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Байгууллагын үйл ажиллагааны төлөвлөгөө, төсвийг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу ТУЗ-өөр батлуулан, биелэлтийг хангаж ажиллах
2. Түрээслэгчдийн гэрээг тайлант онд багтаан байгуулж, өөрчлөлт, сунгалтыг тухай бүр хийж байх
3. Түрээслэгчдийн гэрээг дүгнэж, өр авлагын тооцоо нийлж, гарын үсгээр баталгаажуулж байх
4. Байгууллагын алдагдал, зардлыг хямдруулах талаар тодорхой ажил зохион байгуулж хэрэгжүүлэн ажиллах
5. Ашиглах боломжгүй, актлах шаардлагатай хөрөнгүүдийг холбогдох газарт санал хүргүүлэн шийдвэрлэх

Зөвлөмжийн биелэлтийг Төрийн аудитын газарт 2018 оны 07 сарын 10-ны дотор албан тоотоор ирүүлнэ үү .

ДАРГА БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Л.УЛАМБАЯР